

БАГАНУУР ХК-ИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2020-2022 онд Дэлхий нийтийг хамарсан ковид, түүний дараах хүндрэл дээр ОХУ болон Украин улсын хоорондын дайны байдал нэмэгдэж дэлхий нийтийг хамарсан эдийн засаг, санхүүгийн томоохон хямралыг үүсгэж тус хямрал нь Монгол улсад нөлөөгөө үзүүлж сэлбэг материалын олдоц муудах бүтээгдэхүүний үнийг огцом нэмэгдүүлж байсан бол 2023 он гарснаар харьцангуй тогтворжиж, эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирах хандлагатай болж байна.

Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагаар томоохон дэд бүтэц, техникийн шинэчлэлийн ажлуудыг хийх шаардлага тулгарч байгаа бөгөөд 2023 онд техникийн шинэчлэлд нийт 23,620.4 сая төгрөгийн зарцуулахаар төлөвлөж эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7 /хөрс тээврийн 2, нүүрс тээврийн 2, үйлчилгээний 3 пикап/ техникийг 11,570.6 сая төгрөгөөр шийдвэрлээд байна. Мөн ашиглалтын хугацаа нь дуусч сүүлийн 2 жилийн хугацаанд ажиллаагүй D50KS өрмийн машинд модернизация хийж дизель хөдөлгүүрийг цахилгаан болгон ашиглалтад оруулсан нь өрөмдлөг тэсэлгээний ажлыг найдваржуулсан, хөрөнгө санхүү хэмнэсэн ажил болсон.

Үүнээс гадна компани дотоод нөөцөө боломжоо бүрэн ашиглах, үргүй зардлыг бууруулах, үр ашигтай төслийг эрэлхийлэхийн тулд “Mind mining” төслийн уралдааныг компанийн ИТА-ын дунд 3 сарын хугацатай зохион байгуулаад байна.

Компани хуримтлагдсан өр төлбөрөө цаг тухайд нь төлж барагдуулж чадахгүй байгаа тул /өмнөх онд нийт 14 тэрбум төгрөгийн алданги торгууль хүлээсэн/ нийлүүлэгч компаниуд шүүхэд хандан алданги торгууль нэхэмжлэх болсон талаар албан бичгүүдийг компанид



хаяглан ирүүлсээр байна. Бидний дээрх нөхцөл байдалтай уялдуулан нийлүүлэгч компаниудтай төлбөрийн хуваарь тохирох, зарим худалдан авалтуудыг эрэмбэлж хойшлуулах зэрэг мөнгөн урсгалын нарийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Бид 2023 он гараад “Эрчим хүчний зохицуулах хороо”, “Эрчим хүчний яам”-нд нүүрсний үнэ нэмүүлэх, үнийн зөрүүний алдагдалд төрөөс татаас авах тухай албан хүсэлтүүдийг удаа дараа хүргүүлэн ажиллаж байгаа боловч шийдвэртэй хариуг өнөөдрийн байдлаар өгөөгүй байна.

Нөхцөл байдал хүндхэн байгаа энэ үед Эрчим хүчний яамнаас 2023-2024 оны өвлийн ачаалыг даван туулахад шаардлагатай 200 мян.тн тонн нүүрсийг Багануурын уурхайг олборлохыг үүрэг болгоод байна.

Хүндрэл бэрхшээл их байгаа ч улс орны эрчим хүчний салбарыг түлшээр хангах үндсэн үүргээ 2023 оны эхний хагас жилд амжилттай биелүүлж чадлаа. Үүнд: нүүрс гаргалт, борлуулалтын төлөвлөгөөг 102.3-103.8 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөөг 107.7 хувь, нийт уулын цулын ажлыг 109.9 хувь биелүүлж үйлдвэрлэлийн үндсэн зорилтоо үзүүлэлт тус бүрээр давуулан биелүүлсэн бол орлогын төлөвлөгөөг 105.0 хувиар, зардлын төлөвлөгөөг 88.7 хувиар тус тус давуулан ажилласан байна.

ХОЁР.ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛГЭЛ АЖИЛ

2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд нийт 3 бүлэг, 28 зүйл бүхий 53,231.2 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаагаас 2023 оны 07 сарын 25-ны өдрийн байдлаар 51.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 28 ажлаас бүрэн хийгдсэн 7 ажил хийгдэж буй 20 ажил, хугацаа болоогүй 1 ажилд байна.

№	Хийгдэх ажлууд	Тоо хэмжээ	Гүйцэтгэл, %
1	ТЗБАХ	6 ажил	30.8%
2	Хөрөнгө	6 ажил	58.3%
3	Засварын ажил	16 ажил	57.0%
	Нийт дүн	28 ажил	51.7%

ТЗБАХ					ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					ЗАСВАРЫН АЖИЛ					НИЙТ					2022-2023
Ажлын тоо хэмжээ					Ажлын тоо хэмжээ					Ажлын тоо хэмжээ					Ажлын тоо хэмжээ					
Төлөв	Дууссан ажил	Эхэлсэн ажил	Эхлээгүй ажил	Гүйц	Төлөв	Дууссан ажил	Эхэлсэн ажил	Эхлээгүй ажил	Гүйц	Төлөв	Дууссан ажил	Эхэлсэн ажил	Эхлээгүй ажил	Гүйц	Төлөв	Дууссан ажил	Эхэлсэн ажил	Эхлээгүй ажил	Гүйц	
6		5	1	30.8%	6	2	4		58.3%	16	5	11		57.0%	28	7	20	1	51.7%	49.2%

ТЗБАХ: 6 ажлаас авахад бэлэн нүүрсний нөөцийг сар бүр 300 мян.тн-с буулгахгүйгээр ажиллах. Складаар 15 мян.тн нүүрс олборлож нүүрсний агуулахад нөөцлөх, Нүүрс болон хөрс тээвэрлэлтийн замыг засаж хайргажуулах. Уулын 1-р хэсэгт 12км, Уулын 2-р хэсэгт 19.5км, Өвлийн улиралд ашиглах зорилгоор Уулын 2-р хэсэгт 10 мян.м3 хайрганы нөөц бэлтгэх. Уулын 1-р хэсгийн ашиглалтын 1-р аманд ил зумпф 350.0 мм3, Уулын 2-р хэсгийн 5-р аманд ил зумпфээр 150.0 мм3 ус шүүрүүлж зайлуулах гэсэн 5 ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна. ӨТА-ыг чанартай явуулах үүднээс өрөмдлөгийн талбайг засаж бэлтгэх ажил хугацаа нь болоогүй байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ: 6 ажлаас дууссан 2 ажил нүүрс тээврийн 2

автомашин, хөрс тээврийн 2 автомашин худалдан авах ажил хийгдээд 5 сараас ажиллаж байна. Гүний ус шүүрүүлэх 12 цооног өрөмдүүлэх ажлаас 2 цооногийн өрөмдлөг хийгдсэн. Автокран /50 тн-ы даацтай/ худалдан авах ажил гэрээ хийгдсэн. 6.5 м3-ийн шанагатай гидро экскаватор худалдан авах ажил тендер нь зарлагдсан. Дугуйт бульдозер худалдан авах ажил тендерт оролцогч байхгүй дахин зарласан.

ЗАСВАРЫН АЖИЛ: 16 ажлаас бүрэн дууссан 5 ажил байгаа ба технологи дамжлага №1, №2-ийн ТҮ засвар. ЭШ-10/70 №35 экскаваторын эргэхийн зам, ось ролик солих, ЭКГ-5А №1426 экскаваторын редуктор солих, ТЭМ 2У №1048, №8684-ийн ТР-2 засвар үйлчилгээг хийх гэсэн 5 ажил 100% хийгдсэн. Графикийн дагуу хийгдэж

байгаа 11 ажил хийгдэж байна. 2023 оны засварын графикайн дагуу хөрсний болон гаргалтын экскаваторуудын ТҮ-2, 3 урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх, өрмийн машины ТҮ-2 засварын ажлыг хийх, ЭШ-10/70 №61 экскаваторын эргэхийн зам, ось ролик, венец араа солих, Экскаваторуудын цахилгаан машины урсгал засвар, Экскаваторын шанаганы засварыг хийж нөөц бэлтгэх 8м3-н шанага 2ш, ЭКГ-н 10м3-н шанага 1ш, ЭШ- н 10м3, 15м3, 20м3 шанага тус бүр 2ш-г, 110/6кВ-ын "Уул", "Галуут" дэд станцын урсгал засвар хийх, Дулаан узель, цэвэр бохир усны шугамд үзлэг засварын ажил хийх гэсэн ажиллууд графикайн дагуу хийгдэж байна. ЭШ-20/90 №05 экскаваторын ось ролик солих, ЭКГ-8И №1946 экскаваторын сум солих гэсэн 2 ажил хугацаа болоогүй байна. ТЭМ 2У №1290-ийн ТР-3 засвар үйлчилгээг хийх, Графикайн дагуу хөрс, нүүрсний ТАМ-д

агрегат засвар хийх гэсэн 2 ажлын сэлбэгийн тендер зарласан.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

Багануур ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн хүчин чадал 4,000 мян.тн боловч бид улс орны эрчим хүчний аюулгүй байдлыг эрсдэлд оруулахгүйн тулд 2023 онд суурилагдсан хүчин чадлыг 12.5 хувиар нэмэгдүүлэн 4,500 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулсан. Гэвч эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор станцуудын эрчим хүч үйлдвэрлэл өсч 2023-2024 оны өвлийн ачааллын үед Багануурын уурхайгаас нэмэлтээр авах нүүрсний хэмжээг 200.0 м.тн -оор нэмэгдүүлэх үүргийг ЭХЯ-наас өгсөн. Бид ЭХЯ-нд тус нэмэлт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилт, хийгдэх ажлын жагсаалтыг хүргүүлсэн ба яам Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэх шатандаа байна.

2023-2024 ОНЫ ӨВЛИЙН АЧААЛЛЫН ҮЕД ХИЙГДЭХ УУЛЫН АЖИЛ

	2023 он				2024 он				Нийт
	10 сар	11 сар	12 сар	4-р улирал	1-р сар	2-р сар	3-р сар	1-р улирал	
Үзүүлэлт									Өвлийн ачааллын үед
Нийт олборлолт мян.тн	430.1	459.9	509.5	1399.5	536.5	451.1	422.6	1410.2	2809.6
Нийт борлуулалт мян.тн	430.1	459.9	509.5	1399.5	536.5	451.1	422.6	1410.2	2809.6
Нийт хөрс м.м3	1360.0	1480.0	1460.0	4300.0	1440.0	1300.0	1440.0	4180.0	8480.0
Тээвэргүй м.м3	130	160	160	450	160.0	140.0	160.0	460.0	910.0
Авто хөрс м.м3	1220	1320	1300	3840	1280.0	1160.0	1280.0	3720.0	7560.0

ГУРАВ.ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР БОДЛОГО, МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

Багануур” ХК нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь

заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого (2021-2023), ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо стандарт шаардлагын хүрээнд холбогдох 1 журмыг шинээр боловсруулсан.

Эрсдлийг удирдах, эрсдэлд суурилсан аюулгүй ажиллагааг хангах, осолгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд ажлын байр, ажилбарын эрсдэлийн үнэлгээг дахин сайжруулах, зарим ажлын байр, ажилбарын эрсдлийг шинээр үнэлэх ажлыг зохион байгуулж, нийт 555 ажлын байр, ажилбарын эрсдэлийг дахин үнэлүүлсэн, үүний 137 нь өндөр, 409 нь

дунд, 9 нь бага эрсдэлтэй үнэлэгдсэнийг Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/21 тоот тушаалаар шинэчлэн батлуулж, баталгаажуулсан.

Хэсэг нэгжийн удирдлага, ИТА-дыг ажлын байрны аюул эрсдэлийг илрүүлэн арилгуулах, ажилтнуудыг осол зөрчилгүй ажиллуулах, тэднийг сургах, аюулгүй ажиллагааны хурлаар дамжуулан аюулын талаар мэдээлэл дамжуулах, өдөр тутмын зааварчилгааг эрсдэлд суурилсан байдлаар өгч хэвшүүлэх зэрэгт онцгой анхааран ажиллаа.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДОЛ:

2023 оны эхний хагас жилд компанийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол 1 гарч, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол, объектын гал гараагүй.

Төрөл		2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
ҮОХХ		0	0	0	0	1
ОДТ Үүнээс:	Нийт	6	5	3	0	0
	Техник ашиглалт	4	3	3	0	0
	Технологийн горим зөрчсөн.	2	1	0	0	0
Галын зөрчил		1	0	0	0	0

СУРГАЛТ:

Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн дугаар А/370 тоот тушаалаар батлагдсан сургалт явуулах болон шалгалт авах журмын үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу “ХАБЭА-н сургалтын хөтөлбөр”-ийг 9 үндсэн, 32 дэд сэдвийн хүрээнд 12 цагийн багтаамжтай боловсруулан Үйлдвэрлэл, технологи эрхэлсэн дэд захирлаар батлуулан, Гүйцэтгэх захирлын А/109 тоот тушаалаар, батлагдсан хөтөлбөрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн сар бүрийн 3 дахь долоо хоног бүр ХАБЭА-н сургалтыг танхимаар явуулахад сургалтанд нийт 981 ажилтан хамрагдахаас одоогийн байдлаар 697

ажилтан хамрагдаж, гүйцэтгэл 70,3%, мөн сургалтын үр дүнг үнэлэх шалгалтыг 981 ажилтнаас 156 ажилтан буюу 16,1% шалгалтанд хамрагдсан.


ЭАШТ, ГЭД, АУД сургуулилт: Хэсэг, нэгжийн амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хянах, чиглүүлэх, хамрагдалтыг сайжруулах чиглэлээр хяналт тавьж ажилладаг бөгөөд эхний хагас жилийн байдлаар амилуулах суурь тусламж, гал эсэргүүцэх, аваар устгах дасгал сургуулийг нийт 25 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1563 ажилтныг хамруулсан, хамрагдалт 76%-

тай, өмнөх оноос хамрагдалт 6%-иар өссөн.

Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг ажилтнуудын ажиллах эрх сунгах Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг байгуулан цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа гэсэн сэдвийн хүрээнд ажилтнуудад сургалт хийж, 32 асуулт бүхий 4 хувилбартай тестээр 291 ажилтнаас шалгалт авч аюулгүй ажиллагааны зэрэг олгож баталгаажуулсан. Үүнд: экскаватор, өрмийн машинч, туслах машинч - 192

ХЯНАЛТ:

Ээлжит үзлэг: Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг хийх комисс нь компанийн хэсэг нэгжийн 2023 оны 1 ба 2 дугаар улирлын ХАБЭА-н бичиг баримтууд, машин механизм, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдхүүний техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаа, технологийн ажлын явц, паспортын мөрдөлт, ажлын байрны соёл, эрүүл ахуй, эрүүл мэнд, эмх цэгц, хүн нэг бүрийн



ажлын, тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, түүний ашиглалтанд хяналт шалгалт хийсэн.

ажилтан, зумфны насосчин - 8 ажилтан, диспетчер, техникч - 12 ажилтан, кабель, цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин - 11 ажилтан, өндөр хүчдэлийн шугамын монтёр - 17 ажилтан, цахилгаанчин - 28 ажилтан, ээлжийн мастер, механик - 23 ажилтан тус тус хамрагдсан.

Аюулгүй ажиллагааны хурал зохион байгуулсан байдлыг хэсэг, нэгжээр харуулбал УНХ 23 хурал, УХХ 26 хурал, НБАХ 118 хурал, ТАМАХ 44 хурал, ЯАМХ 43 хурал, ТАМЗХ 125 хурал, ЗХ 25 хурал, ЭХНХ 23 хурал, УШХ 16 хурал хийсэн буюу нийт дүнгээрээ 443 удаагийн аюулгүй ажиллагааны хурлыг зохион байгуулсан байна.

2023 оны 1 дүгээр улирлын ээлжит үзлэгээр хяналтын хуудасны хамаарал бүхий 3910 онооноос ЯАМХ 12.2%-тай, бага эрсдэлтэй, УШХ 13.8%-тай, бага эрсдэлтэй, НБАХ 25.4%-тай, бага эрсдэлтэй, ТАМЗХ 7.8%-тай, бага эрсдэлтэй, ТАМАХ 24.9%-тай, бага эрсдэлтэй, ЗХ 7.9%-тай, бага эрсдэлтэй, ЭХНХ 23.6%-тай, бага эрсдэлтэй, УХХ 18%-тай, бага эрсдэлтэй, УНХ 9.4%-тай, бага эрсдэлтэй гэж дүгнэгдсэн.

2023 оны 2 дугаар улирлын ээлжит үзлэгээр хяналтын хуудасны хамаарал бүхий 3910 онооноос ЯАМХ 1%-тай, бага эрсдэлтэй дүгнэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 11.2%-иар буурсан, УШХ 4.9%-тай, бага эрсдэлтэй дүгнэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 8.8%-иар буурсан, НБАХ 2.2%-тай, бага эрсдэлтэй дүгнэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 23.2%-иар буурсан, ТАМЗХ 0.4%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 7.4%-иар буурсан, ТАМАХ 12.1%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 12.8%-иар буурсан, ЗХ 2.2%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай

харьцуулахад 5.4%-иар буурсан, ЭХНХ 2.2%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 21.4%-иар буурсан, УХХ 6.9%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай

харьцуулахад 11.1%-иар буурсан, УНХ 9.3%-тай, бага эрсдэлтэй үнэлэгдэж өмнөх улиралтай харьцуулахад 0.1%-иар буурсан дүнтэй байна.

ДӨРӨВ.ХҮНИЙ НӨӨЦ



2023 онд үйлдвэрлэлийн төлөвлөгөө 4500.10 тн нүүрс олборлон борлуулахаар өмнөх оноос 170.000 тонноор нэмэгдэн батлагдсан тул зарим хэсэг нэгжүүдийн хувьд ачаалалаас шалтгаалж мөн компанид хэрэгжүүлж байгаа стандарт, төсөл хөтөлбөрүүд дээр хүн хүчийг нэмэх шаардлагатай байсан боловч орон тоог нэмэхгүйгээр зохион байгуулан 1123 ажилтны үндсэн орон тоотой ажиллаж байгаа бөгөөд үүний 159 эмэгтэй, 978 эрэгтэй, 291 ажилтан хэвийн, 832 ажилтан хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаагаас удирдлага 24, мэргэжилтэн 38, ажилтан 48, инженер 75), туслах ажилтан 23, үйлчилгээний ажилтан 118, мэргэжлийн ажилтан 821, гэрээт ажилтан 66 байна.

2023 онд хөрөнгө оруулалтаар хөрсний автосомасвал, гидро экскаватор, бульдозер зэрэг 7 тоног төхөөрөмжүүд нэмэгдэхээр байгаа ч дотоод зохион байгуулалт хийж орон тоог нэмэхгүй байхаар шийдвэрлэсэн.

Ажилчдыг тогтвор сууршлаар нь авч үзвэл нийт ажилчдын 49% нь 10

хүртлэх жил, 25% нь 11-20 жил, 26% нь 21-ээс дээш жил ажилласан ажилчид байна.

Бодлогын чанартай ажил: Эрүүл, боловсролтой, зөв үзэл хандлагатай, эдийн засгийн чадавхитай уурхайчин бий болгох зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж байна.

- Эрүүл уурхайчин хөтөлбөр
- Хүний нөөцийн бодлогын бичиг баримт
- Байгууллагын соёл, сэтгэл ханамжийн судалгаа
- Компанийн бүтцийн өөрчлөлт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Сургалт: Компанийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт ажилтнуудын дунд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хууль, Хувь хүний болон өрхийн санхүүгээ удирдах, хуримтлал болон зарцуулалт сэдвүүдээр тус тус сургалтыг зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сертификаттай сургалтанд 32 ИТА, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтанд 16 ИТА-уудыг хамруулж сертификатыг гардуулсан байна.

Компанийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэсэг нэгж бүрийн инженер болон мастерууд

мэргэжлийн чиглэлээр дотоод сургалтыг зохион байгуулж ажилладаг ба Мэргэжлийн зэргийг нэмэгдүүлэх зорилгоор Технологийн автомашин механизмын засварчин-10, цахилгаанчин-2, гагнуурчин-1, өрмийн машинч-8, нийт 21 ажилтанд зориулан сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, сургалтанд хамруулж мэргэжлийн шалтгалтын комисс шалгалт авч, Гүйцэтгэх захирлын тушаалаар зэргийг нэмэгдүүлсэн.

Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах эрх олгох сургалтанд 303 ажилтан, тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу тэсэлгээ хийх,

тэсрэх материалтай харьцаж ажиллах эрх олгох сургалтанд 7 ажилтан, Ачаа өргөх, краныг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу Краны оператор, Оосорлогч дохиочны эрх олгох сургалтанд 196 ажилтан, Химийн бодистой харьцан ажиллах аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтанд 20 ажилтан тус тус хамрагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/370 тоот тушаалаар батлагдсан Сургалт явуулах болон шалгалт авах журмын үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу ХАБЭА-н сургалтанд жилийн хугацаанд нийт 981 ажилтан хамрагдахаас одоогийн байдлаар 697 ажилтан хамрагдаж, 71,3%-н гүйцэтгэлтэй байна. Сургалт байнгын үйл ажиллагаатай хийгдэж байна.

ТАВ.УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны эхний хагас жилд 8,250 мян.м3 хөрс хуулж 2,226.0 мян.тн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 8,889.3 мян.м3 хөрс хуулж 107.7%, 2,310.9 мян.тн нүүрс олборлон 103.8%, 2,278.0 мян.тн нүүрсийг борлуулж 102.3%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Тайлант оны 5 сард хөрс, нүүрс тээврийн

4 самосвалыг шинээр ашиглалтад орлуулсан нь уулын ажлын үзүүлэлт тус бүрийг 100 дээш хувь давуулан ажиллахад гол түлхэц үзүүлсэн. Нийт уулын цулын 60 хувийг хөрс хуулалт, 12 хувийг шидэлт, 4 хувийг инженерийн ажил, 24 хувийг нүүрс олборлолт, борлуулалтын ажил эзэлж байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны хагас жилээр Биз/төл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нүүрс олборлолт	мян.тн	2,226.0	2,310.9	103.8	84.9
Нүүрс борлуулалт	мян.тн	2,226.0	2,278.0	102.3	52.0
Хөрс хуулалт	мян.м3	8,250.0	8,889.3	107.7	639.3
-тээвэртэй хөрс	мян.м3	7,430.0	7,494.3	100.9	40.0
-тээвэргүй хөрс	мян.м3	780.0	1,259.0	161.4	479.0
Нийт уулын цул	мян.м3	13,312.7	14,635.3	109.9	1322.6
Авахад бэлэн нүүрсний нөөц	мян.тн	300.0	335.0	112.0	74.3

НҮҮРС ОЛБОРЛОЛТ:

Уулын 1-р хэсэг 1,437.4 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 103.8%, Уулын

2-р хэсэг 873.5 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 101.0%, нийт уурхайгаар

2,310.9 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 102.7%-тай биелүүлсэн нь өмнөх оноос 88.9 мян.тн-р, сүүлийн гурван жилийн дунджаас 225.1 мян.тн-оор тус тус өсчээ.

Эрчим хүчний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаагаас гадна 2023 оны 1-5 сард олон жилийн дунджаас эрс

НҮҮРС БОРЛУУЛАЛТ:

Хэрэглэгчдээс ирсэн захиалга, өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтэд тулгуурлан 2023 онд 4,500.1 мян.тн нүүрс борлуулахаар төлөвлөсөн ба эхний хагас жилийн гүйцэтгэлээр 2,278.0 мян.тн нүүрс нийлүүлж төлөвлөснөөс 52.0 мян.тн-оор илүү борлуулаад байна. Тайлант хугацаанд ДЦС-2,3,4, Дархан ДЦС-уудад 2,085.9 мян.тн, Амгалан, Багануурын ДС, болон бусад орон нутгийн ДС-уудад 87.0 мян.тн, бусад жижиг хэрэглэгчдэд 105.1 мян.тн нүүрс тус тус борлуулсан байна.

ХӨРС ХУУЛАЛТ:

Эхний хагас жилд 8,365.0 мян.м3 хөрс хуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,889.3 мян.м3 буюу 106.3% гүйцэтгэлтэй ажилласан. Нийт хөрс хуулалтын ажилд авто тээвэртэй хөрс хуулалт 7,630.2 мян.м3 буюу 101.2%-ийн, тээвэргүй хөрс хуулалт 1,259.0 мян.м3 буюу 151.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оноос тээвэртэй хөрс хуулалт 443.6 мян.м3 буюу 6.2 хувиар өссөн бол тээвэргүй хөрс хуулалт 273.3 мян.м3 буюу 27.7 хувиар өссөн.

2023 оны хагас жилээр 8,889.3 мян.м3 хөрс хуулсан нь сүүлийн 3 жилийн дунджаас 582.0 мян.м3 буюу 6.0%-иар буурсан.

Хагас жилээр тээвэртэй ашиглалтын системээр нийт хөрс

хүйтэрсэн тул станцуудын нүүрсний захиалга нэмэгдэж борлуулалтын хэмжээг өсөхөд гол нөлөө үзүүллээ. 2023 оны хагас жилийн байдлаар уурхай дээрх авахад бэлэн нүүрсний нөөц 351.0 мян.тн байгаа нь байвал зохих нөөцөөс 11.6% илүү байгаа илтгэж байна.



Борлуулалт өмнөх оноос 69.9 мян.тн-р, сүүлийн гурван жилийн дунджаас 196.0 мян.тн оор тус тус өсчээ.

хуулалтын ажлын 85.8 хувийг, тээвэргүй хөрс хуулалтын системээр 14.2 хувийг



гүйцэтгэсэн ба тээвэртэй хөрс хуулалтын ажил жил ирэх бүр нэмэгдэж байгаа нь уурхайн өртөг зардал нэмэгдэх үндсэн нөхцөл болж байна.

ӨРӨМДЛӨГ, ТЭСЭЛГЭЭ

Эхний хагас жилд нийт 6,353.5 мян.м³ хөрс тэслэх төлөвлөгөөтэй байсан ч гүйцэтгэлээр 3,115.7 мян.м³ буюу 49%-ийг хөрсний мөргөцөгт тэсэлсэн. Дээрх уулын цулыг тэслэхийн тулд нийт 168.8 мянган метр өрөмдлөгийн ажил хийхээр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 152.8 мянган метр өрөмдлөгийн ажил хийсэн.

Уулын 1-р хэсэгт ЭШ10/70 №35 болон ЭШ10/70 №50 экскаваторууд 2а давхаргын гарш хэсгийн нүүрсийг нээж ажилласан, мөн тэсэлгээний материал хэмнэх зорилгоор зарим цэвдэгтэй мөргөцгийг тэслэхгүйгээр урьдчилан өрөмдөж гэсгээх ажлыг хийсэн нь үр дүнгээ өгч тэсрэх материалыг хэмнэж чадсан.

УС ШҮҮРҮҮЛЭЛТ

2023 оны эхний хагас жилээр 86 цооног, ил зумфээр нийт ордоос 2,420.0 мян.м³ ус зайлуулахаар төлөвлөснөөс ордын хэмжээнд 85 цооног ил зумфээр нийт 2,458.9 мян.м³ усыг зайлуулж 101.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Усны түвшин оны эхнээс 6 сарын байдлаар Уулын 1-р хэсэгт 1.38м, Уулын 2-р хэсэгт 1.52, нийт ордын хэмжээнд 1.45 м-ээр буурсан. Нийт шүүрүүлсэн усны

94.2%-ийг “Хуцаа”, “Хужирт” болон “Хэрлэн” голд, 0.8%-ийг “Бага гүн” нууранд цутгасан бол 255.9 мян.м³ буюу 4.8%-ийг Багануур ДС-ын хэрэглээнд нийлүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд ус шүүрүүлэх цооногуудыг тогтмол нэмэгдүүлж ажиллаж байгаа боловч гүний усны хүндрэлийг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаа тул 2024 онд усны нарийвчилсан хайгуулыг хийлгэхээр төлөвлөж байна.

НҮҮРСНИЙ НӨӨЦ:

2023 онд балансын нөөцөөс 2,310.9 мян.тн нүүрсийг олборлож 775.7 сая.тн нүүрсний нөөцтэй байгаагаас 548.1 сая.тн нь батлагдсан /эдийн засгийн үр ашигтай/, 227.6 сая.тн нь боломжит /тодорхойх нөхцөлд эдийн засгийн үр ашигтай/ нөөц байна. 2023 оны хагас жилээр олборлосон нүүрсний 478.52 мян.тн буюу 20.7 хувийг “Эрдэнэс Монгол” ХХК-нд бүртгэлтэй лицензийн талбайгаас олборлосон.

НӨХӨН СЭРГЭЭЛТ:

Биологийн нөхөн сэргээлт: Уулын ажлын онцлогоос хамааран хүрээ хязгаарын дагуу овоолгууд бүрэн хэлбэржээгүй, нөхөн сэргээсэн талбай бэлэн бус тул 2023 онд уурхайн талбайд нөхөн сэргээлт хийхгүй ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж Багануур ХК 2030 он хүртэл нийт 1,000,000 мод тарих амлалтын хүрээнд 2022-2025 онд жил бүр 10.0 мянган буюу 4 жилийн хугацаанд 40.0 мянган мод, бутыг суулгацаар гадны байгууллагаас авч тарих бол нийт 960.0 мянган мод, бутыг

өөрийн үржүүлгийн газарт бойжуулан тарихаар тооцсоны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. үүнд:

- Ил талбайд навчит модыг үрээр болон мөчрөөр тарьж, хүлэмжинд шинэс модыг үрээр тарих, үржүүлэх ажлыг эхлүүлсэн. Нийт 200 000 орчим модыг үржүүлж байна.
- 2022 онд хамгаалалтын зурвасаар 10,000ш модыг тарьсан.



Дээрх ажлын хүрээнд тус нэгжид 5 хүлэмж /8*40м/, 5 га дэд бүтэцтэй мод

ЗУРГАА.ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

2023 оны эхний хагас жилд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- ✓ Хөрс тээврийн HD-785 маркийн 100 тоннын даацтай 2 самосвал, нүүрс тээврийн HD-465 маркийн 60 тоннын даацтай 2 самосвалоор техникийн шинэчлэл хийсэн.
- ✓ Үйлчилгээний авто машины парк шинэчлэлийг 3 пикапаар шинэчллээ.
- ✓ D50KS өрмийн машины дизель хөдөлгүүрийн цахилгаан болгон өөрчлөн ажил оруулсан

Уулын тоног төхөөрөмжүүдийн /УТТ/ хувьд 22 машин техникийн 35 удаагийн ТҮ2, ТҮ3 засвар хийхээр төлөвлөсөн, графикийн дагуу 18 удаагийн урсгал засварыг хийсэн, 5 машины урсгал засвар хийгдэж байгаа, хугацаа болоогүй 11 удаагийн урсгал засвар графикийн дагуу хийгдэнэ. Энэ нь нийт засварын ажлын 32% нь засвар хүлээж, 51% нь бүрэн хийсэн, 16% нь хийгдэж байна. ЭКГ-10 №33, 1941, ЭКГ-8И №2074,1946 экскаваторуудын эргэх, болон явах механизмын томоохон урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ЭШ-10/70

үржүүлгийн газар, жижиг оврын трактороор ханган, үндсэн 3, гэрээт 12 ажилтанг нэмж өгсөн.

Хяналт шинжилгээний ажлаар агаар, ус, хөрсний дээжийг авч Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори болон Геологийн төв лабораториудаар шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээр агаарын чанар, усны бохирдол, цацрагийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа нь тогтоогдсон.

Харин дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, Төв аймгийн Баяндэлгэр суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөнөөс Баяндэлгэр суманд 2800ш модыг тариад байна.

№61 экскаваторын баазны засвар, ЭШ-10/70 №35 экскаваторын сумны засварын ажил хийгдэж байна. ЭКГ-10 №476 экскаваторын засвар сэлбэгийн нийлүүлэлтээс шалтгаалан хойшлогдсон.



Технологийн автомашинуудын /ТАМ/ урсгал /агрегат/ засварын гүйцэтгэл 66%-тай байгаа нь НТШ-ын хугацаанаас шалтгаалсан /4 багцтай/ бөгөөд 19 машинд ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн. Үүнээс 6 машины агрегат засвар бүрэн

хийгдсэн ба үүнд 7 машины засвар сэлбэг нийлүүлэлт болон бэлтгэл хангах ажил хийгдэж байгаа ба 6 машины засварын хугацаа болоогүй байна. CAT777№126-хөдөлгүүр хүч дамжуулах ангид бүрэн засвар хийж CAT777 №192,320 №01-н хөдөлгүүр шинээр солигдсон. ZX870 №138-н хөдөлгүүрт бүрэн засвар хийв. CAT777 №161.162.124.193-н хойд барабан, тормозны засвар хийсэн. CAT№175.162.192.111-н амортизаторыг шинээр сольж ажилд гаргасан.

2023 оны эхний хагас үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд нийт 172.3 мян.цаг зогссон

ба үүний 63.4 мян.цаг буюу 36.8%-ийг төлөвлөгөөт зогсолт /төлөвлөгөөт засвар үйлчилгээ, тэсэлгээ зөөвөр нүүдэл, ээлжийн бэлтгэл төгсөлтийн цаг/, 56.8 мян.цаг буюу 32.9%-ийг төлөвлөгөөт бус зогсолтын цаг /техник эвдрэл, сэлбэггүй/, 52.1 мян.цаг буюу 30.2%-ийг үйдвэрлэлийн үйл ажиллагаа болон гадны нөлөөллөөс үүссэн зогсолтууд эзлэж байна. Үүний дүнд нийт тоног төхөөрөмжүүдийн техникийн бэлэн байдлын коэффициент /ТББК/ 0.81, техник ашиглалтын коэффициент /ТАК/ 0.63, бэлэн техник ашиглалт /БАК/ 0.78 хувийн гүйцэтгэлтэй гарсан.


ДОЛОО.САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Багануурын уурхай эхний хагас жилд 100,806.2 сая төгрөгийн орлого олж, 115,846.0 сая төгрөгийн зардал гарган 15,039.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 105,857.6 сая төгрөгийн орлого олж, 102,758.3 сая төгрөгийн зардал гарган, 3,099.3 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 18,139.2 сая төгрөгөөр буюу 220.6 хувиар бууруулан ажиллаа.

Эхний хагас жилд төлөвлөснөөс 52.0 м.тн нүүрс илүү нийлүүлснээр борлуулалтын орлого 2,598.2 сая төгрөгөөр, Япон Улсын хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл болох 677.6 сая иений ханшийн зөрүүнээс 2,053.7 сая төгрөгийн ашиг бүртгэдсэн нь орлого 5,031.6 сая төгрөгөөр давж биелэхэд гол нөлөө үзүүлээ.

Харин зардлын хувьд төлөвлөснөөс тэсрэх материал 4,169.0 сая, дизел түлш 2,158.4 сая, сэлбэг хэрэгсэл 5,422.0 сая, дугуй 685.9 сая, түрээс 1,292.5 сая, ХАБЭА-н зардал 940.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн бол цалин

түүний шимтгэлийн зардал 2,204.1 сая, элэгдлийн зардал 1,571.6 сая төгрөгөөр хэтэрч нийт дүнгээрээ 13,087.7 сая төгрөгөөр буюу 11.3%-ийн хэмнэлт гарган ажиллаа.



Зардлын хэмнэлтийн талаар дурдвал: **а**/2023 онд 5,422.5 мян.м3 уулын цулыг тэслэхээр төлөвлөсөн боловч уулын ажлын шаардлагаар 3,115.8 мян.м3 уулын цулыг тэсэлснээр тэсрэх материалын зарцуулалт 1,071.7 тоннд хүрч 54%-ийн хэмнэлттэй гарсан. **б**/Татварын тухай хуулийн 13.2.8-дах

заалтыг үндэслэн 2023 оны 1-6 сард нийт 3,344 сая төгрөгийн үнэтэй урсгал засварын сэлбэгийн зардлыг үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийн 5%-иас дээш гарсан шалтгаанаар капиталжуулсан нь сэлбэгийн зардлыг бууруулж үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг өсгөж байна. /цаашид ашиглалтын хугацаа дууссан үлдэгдэл өртөг нь буурсан тоног төхөөрөмжүүдийг дахин үнэлэх шаардлагатай байгааг харуулж байна/, **в/** 2023 онд 200 мян.тн нүүрсийг 1,292.5 сая төгрөгийн өртгөөр оператор компаниар тээвэрлүүлэхээр төлөвлөж байсан ч бид тээвэргүй хөрс хуулалтын хэмжээг нэмэгдүүлэх байдлаар шийдвэрлүүлж чадсан тул тус зардал хэмнэгдсэн. **г/** 2023 оны бизнес төлөвлөгөөнд ажилчдад үр дүнгийн урамшуулал цалин олгохгүй байхаар тооцсон ч 2022 оны үйлдвэрлэл санхүүгийн бүх үзүүлэлтүүд биелсэн, ҮЭНХ-оор батлагдсан журмаа мөрдөж ажиллахыг шаардсан тул компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд хуралдаж 3 сараар олгох шийдвэрийг гаргасан. Өнөөдрийн байдлаар тус 3 сарын урамшуулал цалингийн 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгоод байгаа бөгөөд үлдсэн 1 сарын урамшууллыг 8 сард өгөхөөр төлөвлөж байна. **д/** Дизелийн түлшний зардал 2,158.4 сая төгрөгөөр хэмнэсний 1,507.0 сая төгрөг нь нэгж үнийн бууралтаас, 651.3 сая төгрөг нь биет хэмжээг хэмнэснээс үүссэн байна. 2023 онд төлөвлсөн тэсэлгээний ажлыг хийж чадаагүйгээс 232 сая, D50KS дизель өрмийг цахилгаан болгосон, GPS-ийн хяналтыг нэвтрүүлсэн зэргээс хамаарч түлшний зардал 419 сая төгрөгөөр хэмнэсэн.

Бид дунд болон урт хугацааны ТЭЗҮ-д тусгагдасны дагуу хойноос урш чиглэлд уулын ажлын ахилтыг өрнүүлж,

хөрс хуулалтын коэффициентийг бууруулах, тогтворжуулах ажлын хүрээнд УШС-ын шинэчлэл, УДС-ын шинэчлэл, ус шүүрүүлэх гүний цооног, коллекторуудыг шинээр барьж байгуулах ажлуудыг жил дараалан хийсний үр дүнд 2022 оноос эхлэн хөрс хуулалтын хэмжээг 30 хүртэл хувиар буурч, өртөг зардлыг бодитоор хэмнэх боломжийг бүрдүүлж байна.

Хэдийгээр үйл ажиллагааны зардлаа хэмнэж төлөвлөсөн алдагдлыг бууруулж ажилласан боловч шаардлагатай нормт материал, төлөвлөгөөт засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийхгүйгээс гэнэтийн төлөвлөгөөт бус эвдэрлүүд гарч үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсч болзошгүй юм.


Дээрх нөхцөл байдлын улмаас нэг тонн нүүрсний бүрэн өөрийн өртөг 44,466.1 төгрөгт хүрч төлөвлөснөөс 7,576.2 төгрөгөөр, нэг метр куб уулын цулын өртөг 7,021.3 төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 1,680.7 төгрөгөөр тус тус буурсан. Харин өмнөх оноос нэг тонн нүүрсний өртөг 135.2 төгрөгөөр, 1 м3 уулын цулын өртөг 84.6 төгрөгөөр тус тус нэмэгдсэн ба өртөг нэмэгдэхэд 2022 оны сүүлийн хагас жилийн сэлбэг, түүхий эд, шатах тослох материалын үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн.

Багануурын уурхайн нүүрсний ордын геологийн тогтоц нь хэвгий уналтай учраас олборлолт, борлуулалтын хэмжээг тогтмол нэг түвшинд байлгасан ч жил бүр 3-5 метрээр уурхай гүнзгийрч байдгаас хөрс хуулалт, гүний усны шүүрүүлэлт, тээврийн зай нэмэгдэж ашиглалтын зардлыг жил тутам нэмэгдүүлдэг. Мөн тоног төхөөрөмжийн хуучралт, инфляци, гадаад валютын ханшийн өсөлт зэргээс хамаарч нэгж бүтээгдэхүүний өртөг жил бүр өссөөр байдаг учраас өртгийг нэг түвшинд барьж ажиллах боломжгүй юм.

2023 онд 42,545.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн гүйцэтгэлээр 16,735.3 сая төгрөг буюу 39.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэлээрх 16,735.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 11,658.2 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын чанартай буюу шинээр техник тоног төхөөрөмж авахад, 5,077.1 сая төгрөг нь техник зохион байгуулалтын арга хэмжээ буюу их засварын чанартай хөрөнгө оруулалтад зарцуулагдсан байна.


Тайлант хугацаанд улсын төсөвт /ноогдуулалтаар/ нийт 23.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 26.5 тэрбум төгрөгийг төлж 114.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллаа. Нийт ноогдуулсан төлбөрийн 20.9 тэрбум

төгрөгийг компани, 5.5 тэрбум төгрөгийг ажилчидаас төлсөн бол нийт төлбөрийн 23.8 тэрбум төгрөгийг улсын буюу нэгдсэн төсөвт, 2.6 тэрбум төгрөгийг нийслэл орон нутгийн төсөвт хувиарласан байна.



Авлага, өр төлбөр

Авлага эхний хагас жилийн байдлаар 13,182.3 сая төгрөг болж оны эхнээс 2,358.6 сая төгрөгөөр өссөн. Нийт авлагад нүүрсний авлага 5,743.9 сая төгрөг буюу 44.0 хувийг, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс авах авлага 7,438.4 сая төгрөг буюу 66.0 хувийг эзлэж



байна. Нүүрсний авлагыг томоохон хэрэглэгчдээр харуулбал: ДЦС-3 -346.5 сая төгрөг, ДДЦС -934.0 сая төгрөг, Багануур ДС -2,404.3 сая төгрөг, Багануур Илч ХХК -1,084.1 сая төгрөг, Налайхын ДС -370.5 сая төгрөг, Төв чандмань ДЭХГ -313.3 сая төгрөг байна. Эхний хагас жилд шаардлагатай сэлбэгийн урьдчилгаа

төлбөрийг шилжүүлсэн ба тус сэлбэгүүд ондоо багтан орлогод орох тул авлага өссөн мэт харагдаж байна. Харин өмнөх хуримтлагдсан авлагуудыг бууруулах зорилгоор 16 компанийн 281.8 сая төгрөгийг нэхэмжлэн шүүхэд шилжүүлсэн ба ойрын хугацаанд 5 компанийн 415.0 сая төгрөгийн авлагыг нэхэмжлэхээр шүүхэд шилжүүлэх бэлтгэл хийгдэж байна.

Өр төлбөр 2023 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нийт өр төлбөрийн хэмжээ оны эхнээс 8,565.2 сая төгрөгөөр нэмэгдэж 230,167.1 сая төгрөгт хүрсэн. Нийт өр төлбөрийн 67% буюу 153,991.0 сая төгрөгийг богино хугацаат өр, 33% буюу 76,176.1 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзлэж байна.

Багануурын уурхай а/ өртгөөс доогуур үнээр нүүрсээ борлуулж байгаа б/ одоогоор ашиглагдаж байгаа уулын тоног төхөөрөмжүүдийн дундаж насжилт 29 жил, технологийн автомашин механизмуудын дундаж насжилт 9 жилд

хүрч, нийт тоног төхөөрөмжүүдийн 54.5 хувь нь нормт хугацаанаас илүү насжилттай болж, тоног төхөөрөмжүүдийн гэнэтийн эвдрэл гэмтэл нэмэгдэн техник ашиглалт 60-65 хувиас илүү гарч чадахгүй байна.


Дээрх хүндэрлүүдийг шийдвэрлэх зорилгоор сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт дэд бүтцийн ажлуудыг гадны зээлийн эх үүсвэрээр хийж байгаатай холбогдон өр төлбөрийн хэмжээ жил бүр нэмэгдэж байна.



Урт хугацаат өр төлбөр: Урт хугацаат өр төлбөрийн дүн оны эхэнд 78.8 тэрбум төгрөг байсан бол тайлант хугацаанд 76.1 тэрбум болж 2.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2021 онд Япон Улсын ЗГ-аас авсан хөнгөлөлттэй зээл /OL-CLA5-MON1/ 3,465.5 сая төгрөгөөр /ханшийн зөрүүний бууралт 1,198.1 сая төгрөг, төлөлт 2,267.4 сая төгрөг/ буурсан бол тэтгэврийн тэтгэмжийн сан 842.1 сая төгрөгөөр /цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор/ өссөн нь урт хугацаат өр төлбөр буурахад нөлөөллөө.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд:

Дэлхийн банк, ЯУЗГ-ын зээл 30,642.9 сая төгрөг, хүний хөгжлийн сангийн эргэж төлөх нөхцөлтэй 10,061.8 сая төгрөг, ЯУЗГ-ийн 16,008.4 сая төгрөг, ЭТТ ХК-ийн 9,270.0 сая төгрөг, нөөц сан /НХС, АТТС, НСС/ 10,112.9 сая төгрөг төгрөг байна.



Богино хугацаат өр төлбөр:

Богино хугацаат өр төлбөр өнгөрсөн оноос 11,188.6 сая төгрөг буюу 7.8%-иар өсч 153,991.0 сая төгрөгт хүрсэн.

Өглөгийн дэлгэрэнгүй	Эцсийн үлдэгдэл, сая.төг	Эзлэмж
Бэлтгэн нийлүүлэгч	52,972.3	101.1
Цалин	2,872.9	113.9
Шугамын зээл	2,848.3	82.0
ЭМНДШ	11,561.4	94.9
Татвар	51,555.2	107.2
Эргэлтийн зээл	29,100.0	137.8
Хүү	3,004.9	116.5
Бусад	75.9	17.3
БХӨТ-ийн дүн	153,991.0	107.8

Оны эхнээс бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өр төлбөр 574.2 сая, цалингийн өглөг 350.9 сая, татварын өглөг 3,454.8 сая, эргэлтийн зээл /ЭТТ ХХК/ 8,000.0 сая, бусад өр төлбөр 61.9 сая төгрөгөөр өссөн бол НДШ-ийн өглөг 617.7 сая, овердавтын зээл 624.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өглөгийг бүтцээр авч үзэхэд дизель түлш 26.1%, тэсрэх хэрэгсэл 5.2%, технологийн авто машины сэлбэг 26.9%, Уулын тоног төхөөрөмжийн сэлбэг 12.7%, ажил үйлчилгээ 2%, ус шүүрүүлэх 1%, менежментийн төлбөр 26.1%-ийг тус тус байна.

Богино хугацаат банкны зээлийн үлдэгдэлд: “Эрдэнэс Таван Толгой” ХХК-д төлөх зээл 21.9 тэрбум, Эрдэнэс Монгол ХХК-д төлөх 7.2 тэрбум, арилжааны банкуудын цалингийн шугамын зээл 2,848.3 тэрбум төгрөг байна.

Худалдан авалт



2023 онд нийт 148,419.4 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсний 105,874.4 сая төгрөг нь урсгал, 42,545.0 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын чанартай худалдан авалт байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 74,292.2 сая төгрөгийн худалдан авалт хийснээс 52,718.3 сая төгрөг буюу 70.9% нь урсгал, 21,573.8 сая төгрөг буюу 29.1% нь хөрөнгө оруулалтын чанартай худалдан авалт байна.

2023 онд нийт 203 тендер зарлахаар төлөвлөсний 128 тендер буюу давхардсан тоогоор 189 тендер зарлаж 79 тендер амжилттай болсон. Үүнээс 76 тендерийн гэрээ хийгдэж бараа материал нийлүүлэгдээд байна. Тендер нээх хугацаа болоогүй болон үнэлгээний шатанд 17 тендер байна.

НАЙМ.ҮЛДСЭН ХАГАС ЖИЛИЙН ХУГАЦААНД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУД

Үлдсэн хугацаанд ТУЗ-өөр дараах ажлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнд:

1. Эрчим хүчний яам МУ-ын ЗГ-т манай компанийн борлуулалтын 200 тонноор нэмэгдэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэл 2023 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол хийх
2. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн санал
3. Ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгүүдийг актлах саналаа ТУЗ-д оруулах
4. Ашиглагдахгүй болсон сэлбэг материалыг худалдан борлуулах

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ТҮВШИНЖАРГАЛ